

Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тухай танилцуулга

2010 оны 01 дугаар сарын 04-ний өдөр

Завхан аймаг

№	Нэр, огноо, дугаар	Заалтын дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Хувь
Нэг. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ				
		1.Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт		
1	Зохицуулалт хийх тухай 2007.12.19 дугаар 329	2.Жагсаалтад дурдагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. ЦДАШ, дэд станц, зураг төсөл /сая төг/ Цэцэн-Уул-Сонгино-хассан Эрдэнэхайрхан-Завханмандал-7.8 Түдэвтэй-Цэцэн-Уул-20.6 сая Тэлмэн-Тосонцэнгэл-22.2 Асгат-Баянхайрхан-14.0 Улиастай шугам сүлжээний шинэчлэлийн төсөл-хассан Баянтэс бөөний худалдааны төв-хассан. Тэс Арцсуурийн боомтын бөөний худалдааны төв, баталгаат агуулах барьж дуусгах-141.4	ЦДАШ, дэд станц, зураг төсөл /сая төг/ Эрдэнэхайрхан-Завханмандал-7.8-Ажлын гүйцэтгэл 100.0 хувь Түдэвтэй-Цэцэн-Уул-20.6 сая- “Эрчмийн-Ундраа” ХХК гүйцэтгэж, 2009 онд 10.2 сая төгрөг нэмж төлөвлөгдсөн Тэлмэн-Тосонцэнгэл-22.2 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл 100 хувьтй, 2009 онд 172.9 сая төгрөг нэмж тусгагдсан. Асгат-Баянхайрхан-14.0- Ажил бүрэн хийгдсэн Тэс Арцсуурийн боомтын бөөний худалдааны төв, баталгаат агуулах барьж дуусгах-141-“Зост өргөө ХХК барьж ашиглалтад хүлээлгэж өгсөн.	100.0
2	Зохицуулалт хийх тухай 2007.12.21 дугаар 335	3.Жагсаалтад дурдагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. Цагаанхайрхан эмнэлгийн барилга-5.5 сая төг БГХӨТГ-ын засвар-29.9 сая төг Түдэвтэй-Асгат-Баянтэс сумдын 90км ЦДАШ-ын засвар-120.0 сая төг	Цагаанхайрхан сумын эмнэлгийн барилга-5.5 сая төг-ийн ажил бүрэн хийгдсэн. БГХӨТГ-ын засвар-29.9 сая төг-Зуурмаг ХХК ажлыг гүйцэтгэж дуусгалаа. 2008-2009 онд 165.90 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр нэмж тусгагдан барилгыг ашиглалтад хүлээлгэж өгсөн. Түдэвтэй-Асгат-Баянтэс сумдын 90км ЦДАШ-ын засвар-120.0 сая төгрөгийн ажлыг “Алс” ХХК гүйцэтгэсэн.	100.0
3	Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай 2007.12.26 дугаар 349	2.Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашины хотын дотор хуанлын хоногт дундажаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашины хотын дотор хоногт дундажаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дундажаар 70 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай.	Энэ тогтоолд заасан лимитийг хэрэгжүүлэх журам боловсруулж, аймгийн Засаг даргын захирамжаар батлан бүх төсөвт байгууллагад хүргүүж, мөрдөн ажиллаж байна.	100.0
		12.Энэ тогтоолд заасан нийтлэг жишгийг баримтлан аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудын автомашин ашиглалтын журам, автомашины тоо, төрлийг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аймагт төрийн байгууллагуудад автомашин ашиглах журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж байна. Журамд автомашины тоо, ашиглах лимит, эзэмших, ашиглах хуваарь, байгууллагын болон жолооч нарын хүлээх үүргийг тодорхой тусгасан.	100.0

4	Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг сайжруулах зарим арга хэмжээний тухай 2008.04.02 дугаар 126	2.Монгол Улсын дунд хугацааны буюу 2009-2011 оны төсвийн төслийг Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт, тухайн салбарын мастер төлөвлөгөөнд тодорхойлсон зорилго, үр дүнг хангахад чиглүүлэн бүтээгдэхүүн хөтөлбөрт суурилсан төлөвлөлтийн зарчмаар боловсруулах арга хэмжээ авч ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.	2009-2011 оны төсвийн төслийг хөтөлбөрт суурилсан төлөвлөлтийн зарчмаар боловсруулах тухай Улаанбаатар хотод зохион байгуулагдсан санхүүгийн ажилтны сургалт семинарт холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулж, төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлж, 2009, 2010 оны төсөв, 2011-2012 оны төсвийн төсөөллийг энэ зарчмаар боловсруулаа.	90.0
5	Төсвийн зардлыг хэмнэх, зарим арга хэмжээний тухай 2008.04.02 дугаар 128	2а.Сургууль эмнэлгээс бусад төсөвт байгууллагуудад эд хөрөнгө худалдан авах зардлыг 50 хувиар, урсгал засварын зардлыг 20 хувиар бууруулах	Төсөвт байгууллагуудад 2009 онд эд хөрөнгө худалдан авах зардал төсөвт тусгагдаагүй бөгөөд аймгийн ИТХ-аас хөрөнгө бэлтгэх зөвшөөрлийг олгоогүй болно.. Урсгал засварын зардал хүлээгдэж буй гүйцэтгэлээр 32.0 хувиар буурсан дүнтэй байна.	100.0
		2б.Төв суурин газрын төсвийн байгууллагуудад халаалтын хэмнэлтийн горим сонгох, цахилгаан усыг хэмнэж, ариг гамтай зарцуулах	Төсвийн байгууллагуудын гэрэл, цахилгаан, цэвэр бохир усны зардалд хяналт тавьж ажилласнаар 2009 онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 20.0 сая төгрөг хэмнэгдлээ.	100.0
		2в.Гадаад албан томилолт, гадаад зочны зардлыг 30 хувиар бууруулах, УИХ-ын болон орон нутгийн хурлын сонгуулиуд болох гэж байгаатай холбогдуулан төрийн захиргааны байгууллагын дотоод албан томилолтыг багасгах	Гадаад албан томилолт болон гадаад арга хэмжээний зардалд 2009 онд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй бөгөөд ОХУ-ын Тува улсын Засгийн газрын тэргүүний айлчлал, хилийн уулзалт, ах дүүгийн найрамдалт Солонгос улсын Сосан хотын төлөөлөгчдийг хүлээн авах зэрэг үйл ажиллагааны зардлыг “Эрчимтэй хөгжлийн Завхан сан”-гаас гаргасан.	100.0
		2г.Электрон шуудан, интернетийн холбоо ашиглах замаар шуудан холбоо, бичиг хэргийн зардлыг 10-аас доошгүй хувиар хэмнэх	Электрон шуудан, интернетийн холбоо ашиглаж байна. Холбоо, бичиг хэргийн зардал 2009 онд хэтрээгүй байна.	90.0
		2д.Дүрэмт хувцсыг гамтай хэрэглэж, эдэлгээний хугацааг уртасгах замаар хэмнэлт бий болгох, тодорхой салбаруудад дүрэмт хувцас хэрэглэхээс татгалзах, хугацааг түр хойшлуулах	Аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд дүрэмт хувцас хэрэглэж, бусад байгууллагууд дүрэмт хувцас хэрэглээгүй байна. Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудын дүрэмт хувцасны зардлыг 2009 онд төсөвт тусгаагүй болно.	90.0
		2е.Ажлын байрны ачааллыг жигдрүүлэн нягтруулж зарим орон тоог чөлөөлөх, чөлөөтэй орон тоонд томилгоо хийхгүй байх, 2008 оныг дуустал цалин орон тоог нэмэгдүүлсэн шийдвэр гаргахгүй байх	Улсын төсөвт байгууллагуудад 3595, нутгийн захиргааны байгууллагуудад 566 албан хаагч ажиллахаар төлөвлөгдөж, одоо төсөвт байгууллагад 3549, нутгийн захиргааны байгууллагад 550 хүн ажиллаж, цалин орон тоог нэмэгдүүлэхгүй байх зарчимталж байна. Засгийн газрын шийдвэрийн дагуу тооцоход сумдад 23 орон тоо дутуу ажиллаж байна.	100.0
6	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай 2008.04.23 дугаар 148	2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт бий болсон хөрөнгийн үнэ, өртөг, тоо хэмжээ, эзэмших этгээдийн талаархи саналаа бусад холбогдох материалын хамт тухай бүр Төрийн өмчийн хороонд ирүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежер нарт даалгасугай.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн судалгааг гаргаж, улсын комиссын актыг үндэслэн данс бүртгэлд тусгаж, орлого авсныг хянаж, хөрөнгийн бүртгэлийг шинэчилж, аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, дүн мэдээг хугацаанд нь Төрийн өмчийн хороонд хүргүүлж байна.	100.0

7	Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах өөрчлөн байгуулах чиглэл батлах тухай 2008.05.14 дугаар 182	2."Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах өөрчлөн байгуулах чиглэл"-д тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж дүнг Засгийн газарт жил бүр танилцуулж байхыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	"Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах өөрчлөн байгуулах чиглэл"-ийн дагуу санал боловсруулж, төлөвлөгөө гарган ээлж дараатай шийдвэрлэж байна. 2009 онд нийтийн аж ахуйн үйлчилгээний "Амь-Ус" трейд компаний халаалтын 1 дүгээр зуухыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 36 дугаар тогтоолоор менежментийн гэрээгээр хувьчлаад байна.	70.0
8	Чиглэл батлах тухай 2008.05.14 дугаар 184	1.Монгол Улсыг хөгжүүлэх сангаас улсын эдийн Засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхөд 2009-2015 онд баримтлах чиглэлийг хавсралтын ёсоор баталсугай.	Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхдөө энэ чиглэлийг баримталж, тэргүүлэх салбарын хэмжээнд оруулах хөрөнгийн талаарх саналаа 2009 оны төсөвт оруулахаар санал боловсруулж хүргүүлсэн боловч төсвийн тодотголоор хасагдсан байна. 2010 онд энэ сангаас 3.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгдсөн.	90.0
9	Төрийн өмчит хувьцаат компани байгуулах тухай 2008.06.03 дугаар 233	3."Алтай-Улиастайн дамжуулах сүлжээ" "Тайшир усан цахилгаан станц" "Гуулин усан цахилгаан станц" "Богдын гол усан цахилгаан станц" "Тосонцэнгэл усан цахилгаан станц" "Завханмандал усан цахилгаан станц" "Цэцэн-Уул усан цахилгаан станц" хязгаарлагдмал хариуцлагатай компаниудыг шинээр үүсгэн байгуулж, тэдгээрийг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн охин компаний хэлбэрээр ажиллуулсугай.	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани байгуулагдан ажиллаж байна. Богдын гол, Тосонцэнгэл, Цэцэн-Уул, Завханмандалын усан цахилгаан станцуудыг дотоод шугам сүлжээний хамт энэ компаний мэдэлд шилжүүлсэн.	70.0
10	Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үе шатыг батлах тухай 2008.06.18 дугаар 256	3.Дунд хугацааны төсөв, төсвийн ерөнхийлөн захирагчийн зарлагын хязгаар боловсруулахад шаардагдах төсвийн баримт бичиг, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг тогтоосон хугацаанд чанартай боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдэд үүрэг болгосугай.	Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг энэ тогтоолоор батлагдсан хугацаанд боловсруулж холбогдох газруудад хүргүүлсэн. 2011-2012 оны төсвийн төсөөлөл, аймгийн 2010 оны төсвийг боловсруулж Сангийн Яаманд хүргүүлсэн.	90.0
11	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2008.12.03 дугаар 50	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандивын хөрөнгөөр 2004-2008 онд төрийн болон орон нутгийн өмчлөлд бий болсон хөрөнгийг бүртгэх, үнэлэх, санхүүгийн тайланд бүрэн тусгах ажлыг 2009 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2008 оны төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллогоор Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын эд хөрөнгийг нүд үзэн тоолж, улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, зээл, тусламж, хандив, бэлэглэлээр бэлтгэгдсэн хөрөнгийг тусгай маягтаар хөтөлж, бүртгэлгүй хөрөнгийг тайланд тусгуулах арга хэмжээг авлаа.	100.0
		4.Монгол Улсын геодезийн цэг, тэмдэгтийн нарийвчилсан тооллогын ажлыг 2010 оны эхний хагас жилд багтаан хийж дуусган ашиглалт, хадгалалт, хамгаалалтад нь хяналт тавьж ажиллахыг ...бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.	Бэлтгэл ажлыг хангаж байна. /Хугацаа болоогүй/	-

		6.Өрхийн эмнэлгийн барилга, эд хөрөнгө болон “Эмийн эргэлтийн сан”-д эзэмшүүлсэн хөрөнгийг орон нутгийн өмчлөлд бүртгэх, ашиглалтад нь хяналт тавьж, ажиллах арга хэмжээ авахыг ..аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Өрхийн эмнэлгүүдийн болон эмийн эргэлтийн сангийн эд хөрөнгийн тооллогыг аймгийн Засаг даргын захирамжаар комисс томилон явуулж, орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлав. Аймгийн хэмжээнд эмийн эргэлтийн сангийн эргэлтийн хөрөнгө 71.3 сая төгрөг, үндсэн хөрөнгө 19.3 сая төгрөг, нийт 90.7 сая төгрөгийн хөрөнгө тоологдлоо.	100.0
		8.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшил газар болон баталгаажуулсан хэмжээг тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай бүр Төрийн өмчийн хороотой урьдчилан зөвшилцөж байхыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Одоогоор баталгаажуулсан газрын хэмжээг өөрчлөх санал гараагүй байна.	90.0
		9.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоор эд хөрөнгө дутагдуулсан хуулийн этгээдийн удирдлага, холбогдох ажилтанд хариуцлага тооцох, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч, дүнг Төрийн өмчийн хороонд хүргүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	2008 оны төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогоор аймгийн хэмжээнд 42.8 сая төгрөгийн эд хөрөнгө данс бүртгэлээс дутсан дүн гарсан. Үүнд: Дөрвөлжин сумын Хомын бага сургуулийн 26.7 сая төгрөгийн барилга, хүн эмнэлгийн 5.3 сая төгрөгийн барилга, Шилүүстэй сумын Хүн эмнэлгийн 6.5 сая төгрөгийн УАЗ-469 маркийн автомашин, 11 жилийн сургуулийн 0.7 сая төгрөгийн махны зоорь, Эрдэнэхайрхан сумын ЗДТГ-ын 63 толгой мал орж байна. Үүнээс Дөрвөлжин сумын Хомын бага сургуулийн болон хүн эмнэлгийн барилгын, Шилүүстэй сумын 11 жилийн сургуулийн махны зоорийн асуудал бүрэн шийдвэрлэгдсэн.	90.0
12	Зарим албан тушаалын цалингийн жишгийг тогтоох тухай 2009.03.18 дугаар 76	1.Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг дор дурдсанаар тогтоож, 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Аймгийн Засаг даргын орогч 424230-460270 Сумын Засаг даргын орлогч 290250-380314	Тогтоолыг бүх сумдад хүргүүлэн аймаг сумдын Засаг даргын орлогч нарын цалинг шинэчлэн тогтоолоо.	100.0
13	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2009.04.01 дугаар 93	1.Тендерийн урилга, үр дүнг Засгийн газрын Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд /www.e-procurement.mn/ цаг хугацаанд нь бүрэн тавьж , гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг нээлттэй, ил тод мэдээлж байсугай.	Хуулийн дагуу 2009 онд худалдан авах ажлын мэдээллийг ВЭБ сайтад бүрэн мэдээлсэн. Улсын төсвийн хөрөнгөөр:1.Шилүүстэй сумын сургуулийн болон хичээлийн байрны засварын ажил /2009.05.22/ 2.Инженерийн хийцтэй уст цэг шинээр барих ажил /2009.04.29/ Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр: 1.Улиастай хотын доторх зарим замыг хатуу хучилттай болгон сайжруулах ажил	100.0
		2.Захиалагч бүр жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аливаа хяналт, аудитын тайлан, дүгнэлт, иргэд болон байгууллагаас гаргасан гомдлын тоо, агуулга, шийдвэрлэсэн байдлын талаар байгууллагын самбарт нийтэлж, нийтэд ил тод хүргэж байсугай.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж, Сангийн яамны ВЭБ сайтад тавьсан. 2008 оны худалдан авах ажиллагаанд аудитын дүгнэлт хийлгэж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн. Худалдан авах ажиллагааны талаар гомдол гаргасан тохиолдол байхгүй байна.	100.0

		3.Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, ажилтнуудын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх болон худалдан авах ажиллагааны чиглэлээрх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж байсугай	2009 оны худалдан авах ажиллагааг төлөвлөх, 2008 оны ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар сумдын төрийн сангийн төлөөлөгчид, барилгын захиалагч, гүйцэтгэгчид, Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудад 3 удаа сургалт явуулж, зөвлөмж гаргалаа.	100.0
		4.Харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ хууль зөрчиж байгаа нийтлэг, дутагдлыг арилгаж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулж байсугай.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй 4 объектын тендерийг нээлттэй зарлаж, урилгыг ВЭБ сайт, Үнэн, Өдрийн сонинд ил тод нийтэлсэн. Үүнд: Шилүүстэй сумын сургуулийн хичээлийн болон дотуур байрны засвар, Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажил, 20, 40 айлын орон сууцны цахилгааны хаалттай дэд өртөө, Улиастай хотын доторхи хатуу хучилттай зам зэрэгт гүйцэтгэчийг шалгаруулж, ажлыг гүйцэтгэсэн.	100.0
		5.Захиалагч бүр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллан, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай бүрт мөн хуулийн 49.2-т заасан баримт бичиг, материалыг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалж байсугай.	Хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж, шалгарсан 8 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Хуулийн 49.2-т заасан бичиг баримтын бүрдүүлэлт 90.0 хувь байна. Барилга ашиглалтад оруулсны дараа Улсын комиссын акт, бусад бичиг баримтыг бүрдүүлж, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын архивт хадгалж байна. 2008 оны бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой бичиг баримтыг архивын нэгж болгон аймгийн архивт шилжүүлж, 2009 оны баримтыг архивын нэгж болгож байна.	90.0
14	Монгол Улсын төсвийн орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээний ангилалыг батлах тухай 2009.04.08 дугаар 99	2.Үйл ажиллагааны зардлын эх үүсвэр дутагдсан тохиолдолд өр үүсгэхгүй байх зарчим баримтлан төсвийн зарлагын арга хэмжээний ангиллын дагуу бусад арга хэмжээний зардлаас /үүнд аюулгүй байдлыг хамгаалах, стратегийн болон онцгой байдлын нөөцийн зардал хамаарахгүй/ нийт 10 хүртэл хувийг “Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний урсгал зардалд шилжүүлэх эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосугай.	Энэ оны урьдчилсан гүйцэтгэлээр аймгийн төсөвт байгууллагууд 200.0 сая төгрөгийн өглөгтэй, 51.3 сая төгрөгийн авлагатай байна. Төсвийн зарлагын ангилалыг заасан хэмжээнээс хэтрүүлж шилжүүлээгүй	70.0
15	Зарлагын хязгаар батлах тухай 2009.07.22 дугаар 220	1.Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2010 оны төсвийн зарлагын хязгаар болон 2011-2012 оны зарлагын хязгаарын төсөөллийг хавсралт ёсоор баталсугай. /Завхан: 2010 онд 4174.4 сая төг, 2011 онд 5.074.5 сая төг, 2012 онд 5,793.1 сая төг/	Төсвийн зарлагын хязгаарыг баримталж, аймгийн 2010 оны төсвийн төсөл, 2011-2012 төсвийн төсөөллийг боловсруулсан.	100.0
		2.Батлагдсан төсвийн зарлагын хязгаарт багтаан 2010 оны төсвөө боловсруулахыг бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Аймгийн 2010 оны төсвийн төслийг 4500.0 сая төгрөгөөр төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн. Аймгийн 2010 оны төсөв 4300.0 сая төгрөгөөр батлагдсан.	100.0
16	Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө бэлтгэх ажлыг журамлах тухай 2009.07.29 дугаар 234	2.Төрийн өмчит хуулийн этгээд нь дараа онд хэрэгцээтэй байгаа үндсэн хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, тэдгээрийг худалдан авахад шаардагдах зардлын төсвийн төслийн саналыг тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний дотор Төрийн өмчийн хороонд ирүүлж байхаар тогтоосугай.	Тогтоолыг төрийн өмчит байгууллагуудад хувилан хүргүүлж мөрдүүлэх арга хэмжээ авч байна.	70.0

17	Төрийн албан хаагчид болон иргэдийг орон сууцаар хангах арга хэмжээний тухай 2009.10.14 дугаар 321	2.Барьж дуусган улсын комисст хүлээлгэж өгсөн арилжааны банкны зээлийн барьцаанд байгаа орон сууцыг м. кв талбайн үнийг 650.0 /зургаан зуун тавин/ мянган төгрөгөөс хямд байх зарчим баримтлан “Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК-иар дамжуулан төрийн албан хаагчдад урт хугацаатай зээлээр олгохыг....Засаг дарга нарт даалгасугай.	Аймагт хуваарилагдахаар эрх олгож байгаа орон сууцуудыг төрийн албан хаагчдад шалгуурыг хангасан байдлыг харгалзан шалгаруулж олгох арга хэмжээ авна	70.0
18	Мөнгөн урамшууллын хэмжээ тогтоох тухай 2009.11.25 дугаар 350	1Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд тэдгээрийн улсад болон гурилын үйлдвэрт нийлүүлсэн хүнсний буудайн нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг 50.0 /тавин/ мянган төгрөг байхаар тогтоосугай.	2009 онд улсад болон гурилын үйлдвэрт улаан буудай нийлүүлээгүй тул мөнгөн урамшуулал олгогдохгүй болно.	100.0
2.Хөдөө аж ахуй				
19	Ой угтсан бүтээлч ажлын тухай 2007.04.04 дугаар 86	1.Монгол Улсад газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 50 жилийн ойг 2009 оны 11 дүгээр сард тэмдэглэх болсонтой холбогдуулан 2 жилийн бүтээлч ажил өрнүүлж, ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг.... Аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Монгол Улсад газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 50 жилийн ойг угтаж хийх 2 жилийн бүтээлч ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2007 оны 144 дүгээр захирамжаар батлан хэрэгжүүлж, 98.3 хувийн биелэлттэй байна. Аймагт 50 жилийн ойг ургацын баяртай хамтруулан тэмдэглэж, улмаар улсын хэмжээнд зохион байгуулагдах арга хэмжээнд оролцохоор шалгарсан 15 хүнд хүндэтгэл үзүүлж, дурсгалын зүйл олголоо.	100.0
20	“Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээий тухай 2009.01.14 дугаар 12	4а.Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудад усалгаатай үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамалын тариалалтыг нэмэгдүүлэх, техник, тоног, төхөөрөмж, үр, бордоо, ургамал хамгааллын бодисын хүрэлцээ хангамжийг сайжруулах замаар хурааж авах ургацын хэмжээг өсгөж аймаг болон бүс нутгийн дотоодын хэрэгцээг хангах нөхцлийг бүрдүүлэх	Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 29 дүгээр тогтоолоор батлуулан, Засаг даргын захирамжаар комисс байгуулан төлөвлөгөөтэй ажиллуулж байна.. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Тэлмэн, Сонгино, Яруу, Цэцэн-Уул, Түдэвтэй, Алдархаан сумдын услалтын системийг сэргээн засварлаж, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэв. Сум бүрт агропарк байгуулж, иргэд хүлэмжийн тариалан эрхэлж, тарималын нэр төрлийг нэмэгдүүллээ. 2009 онд 8 тн овьёосны, 6 тн хөх тарианы, 27.0 тн улаан буудайн, 80.0 тн төмсний, 50.3 кг хүнсний ногооны үрийг аж ахуйн нэгж, иргэдэд зээл, тусламжаар олгож, 1670.7 тн төмс, 876.8 тн хүнсний ногоо хурааж авлаа. Дархан-Уул аймаг дахь Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнд хөрсний агро химийн шинжилгээ хийлгэхээр 600 дээж хүргүүлж, газар тариалангийн зориулалтаар 10 гаруй трактор авч ашиглаж байна.	100.0
		4в.Тэжээлийн ургамалын тариалалтыг нэмэгдүүлэн мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн нэгжүүдийг хот, суурин газрын бүсэд шинээр байгуулах замаар хүн амын мах, сүүний хангамжийг сайжруулах	“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Улиастай, Тосонцэнгэл, Алдархаан, Цагаанхайрхан, Тэлмэн сумдад сүүний, махны чиглэлийн үхэр, гахай, шувууны чиглэлийн аж ахуйнууд үйл ажиллагаа явуулж байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас фермерийн аж ахуй эрхлэх 10 төсөлд 120.9 сая төгргийн хөнгөлөлттэй зээл олголоо.	90.0

21	Улсын нөөцөөс өвс, тэжээл хөнгөлөлттэй үнээр худалдах тухай 2009.01.21 дугаар 17	5.Улсын нөөцөөс хөнгөлөлттэй үнээр худалдалах өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, зөрчил гаргуулахгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн хэмжээгээр улсын нөөцийн 4 фондоос 1475 тн өвс, 700 тн хорголжин тэжээлийн үнийг 50 хувь хямдруулж, сум багийн Засаг даргын хяналтанд зөвхөн малчдад аливаа зөрчилгүй худалдааллаа.	100.0
22	“Улсын сайн малчин”...шалгаруулах тухай 2009.02.04 дугаар 34	1.Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан.... Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Оройн товгор багийн малчин Гүндсамбын Галаарай, Түдэвтэй сумын Аргалант багийн малчин Данаажавын Батсайхан, Тэлмэн сумын Шургах багийн малчин Сандуйжавын Энхбаатар... нарыг “Улсын сайн малчин”-аар тус тус шалгаруулсугай.	Шагналыг албан ёсоор хүндэтгэлтэй гардуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэслэлээр сурталчлан, арга туршлагыг залуу малчдад эзэмшүүлэх, зөвлөгөө өгүүлэх арга хэмжээг авч байна.	100.0
23	Хурдан морины бүсийн уралдааны 2009 оны хуваарийг тогтоох тухай 2009.02.04 дугаар 35	1.Хурдан морины...Баруун бүсийн зуны уралдааныг 2009 оны 7 дугаар сарын 25-26-ны өдөр Завхан аймагт ...зохион байгуулахыг Монголын морин спорт, уяачдын холбоонд зөвшөөрсүгэй.	Хурдан морины Баруун бүсийн уралдааныг зохион байгуулах бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, уралдааныг Тэлмэн сумын нутаг “Хүрэн тал”-д явуулж, 13 аймгийн 1055 хурдан морьд уралдаж, 128 бөх барилдсан. Аймгийн Засаг даргын захирамжаар уралдааныг зохион байгуулах хороог байгуулж, ажлын чиг үүргийн хуваарилан хариуцуулж, зохион байгуулалтын өндөр түвшинд ажилласан.	100.0
24	Хөрөнгө гаргах тухай 2009.04.08 дугаар 101	1.Мал аж ахуйн хаваржилтын байдал хүндэрсэн Баян-Өлгий, Завхан, Увс, Хөвсгөл аймагт улсын нөөцөөс 819.0 тонн өвс, 520.0 тонн тэжээлийг буцалтгүй тусламжийн хэлбэрээр үнэгүй олгох...-ыг зөвшөөрсүгэй.	Буцалтгүй тусламжаар 200 тн тэжээлийг татан авч, сум багийн Засаг дарга нараар дамжуулан хувиар гаргаж, өвөлжилт, хаваржилт хүндэрсэн газрын малчдад олгов.	100.0
25	Төлөвлөгөө батлах тухай 2009.07.08 дугаар 208	2.Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын эхний үе шат /2009-2015 он/-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан арга хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтарч, төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагтай холбоотой заалтуудыг хэрэгжүүлэх талаар сумдын Засаг дарга, ХАА-н ажилтан, мэргэжилтэн, багийн Засаг дарга, малчдын төлөөлөл 208 хүний бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулж, малчдад сурталчилж байна	50.0
26	2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэжээний тухай 2009.07.22 дугаар 221	10а.Аймгийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, энэхүү тогтоолын хавсралтаар баталсан 2009 онд бэлтгэх хадпан тэжээлийн даалгаварыг хэрэгжүүлэх ажлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах /Завхан аймаг: өвс 40.0 мян тн, ногоон тэжээл 0.5 мян тн, үйлдвэрийн тэжээл 2.0 мян тн, гар тэжээл 2.0 мян тн/	2009-2010 оны мал аж ахуйн болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөгөө гарган бүх сум байгууллагуудад хүргүүлж хэрэгжүүлж байна. Аймгаас бүх сумдад 3 удаа төлөөлөгч ажиллуулж, өвөлжилтийн бэлтгэл ажлын явц байдалтай танилцан холбогдох арга хэмжээг авч, өвөлжилтийн байдлын талаар холбогдох газруудад мэдээлэл хүргүүлэн зохих тусалцааг авч байна. Отор нүүдэл хийж байгаа малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд болон бусад арга хэмжээнд зориулж Засгийн газраас 50.0 сая төгрөг, 2.1 сая төгрөгийн эм биобэлдмэл олголоо. Энэ онд аймгийн ихэнх нутаг гантай байсан боловч боллоцгоог дайчлан аймгийн хэмжээнд 10.4 мянган тн хадлан, 549.1 тн ногоон тэжээл, 996.3 тн гар тэжээл, 125.0 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэлээ.	90.0

		10б.Орон нутгийн эрчим хүчний үйлдвэр, нийт аж ахуйн нэгж, иргэдийн өвлийн бэлтгэлийг хангуулах, түлээ, нүүрс нөөцлөх, түлш шатахуун татан авах ажлыг зохион байгуулж, энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор шатахуун дизелийн түлшний 20-иос доошгүй хоногийн нөөцийг бүрдүүлж, төв, суурин газрын барилга байгууламж, орон сууцны цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний ээлжит засвар, үйлчилгээ, угаалга, туршилт, автозам, харилцаа холбооны шугамын арчлалт, үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд нь хийж дуусгах арга хэмжээ авах	1 дүгээр уурын зуухны 8 тогоонд шинэчлэл хийж, орон сууцны орцны хаалтуудыг сольж, засвар үйлчилгээг бүрэн хийлээ. Аймагт өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөтэй уялдуулан халаалтын үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдээс айл өрх албан байгууллагуудтай хамтран ажиллах маркентгийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж байна. Аймагт шатахуун, дизелийн түлшний зохих нөөцтэй байна. “Завхан-А33А” ХХК-иас Солонгот, Согоот, Загастай, Ганцын даваануудад 6-7 хүн, самосвал, автогрейдер, бульдозер зэрэг техникүүдийг тогтмол хугацаанд ажиллуулж, шаардлагатай үед даваануудыг онгойлгох арга хэмжээ авч байна.	100.0
		10в.Нийтийн тээврийн хэрэгслэл , тэдгээрийн грашийн засвар, дулаалгыг хугацаанд нь чанартай хийж, сэлбэг хэрэгсэл, өвлийн улиралын шатахуун, тослох материалыг зохих хэмжээнд нь нөөцөлж, иргэдэд найдвартай үйлчлэх нөхцөл бүрдүүлэх	Нийтийн тээврийн үйлчилгээнд Улиастайгаас Улаанбаатарын чиглэлд “Улиастай шинэ эхлэл хоршоо”, аймгийн төв доторх үйлчилгээнд хувийн тээврийн автобусууд үйлчилж, Тээвэр, авто замын газартай гэрээ байгуулан ажиллаж байна. Өвөлжилтийн бэлтгэл бүрэн хангагдсан.	100.0
		10г.Нутаг дэвсгэрийнхээ зуншлага, намаржилтын байдалтай уялдуулан мал өвөлжүүлэх, отор нүүдэл хийх, хадлангийн газрын ашиглалтын төлөвлөгөө, зураглал гарган мөрдөн ажиллаж, шаардлагатай үед нөөц бэлчээрийг ашиглах талаар гэрээ байгуулах асуудлыг урьдчилан тохиролцох	Аймгаас ажлын хэсгүүд томилон Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгийн нутагт мал өвөлжүүлэх болон аймгийн сум хооронд мал шилжүүлэн өвөлжүүлэх гэрээ хэлцэл хийж, гадны аймгийн нутагт 265 өрх, 167.7 мянган мал, өөрийн аймгийн сум хооронд болон Дархан цаазат, байгалийн цогцолбор газрууд, хилийн зурвас нутагт 383 өрх, 228.1 мянган мал отроор өвөлжиж байна.	100.0
		10д.Аймаг, сумын хэмжээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг шаардлагатай цэгүүдэд байршуулах арга хэмжээ авах	“Эрчимтэй хөгжлийн Завхан сан”-гийн хөрөнгөөр аймгийн нөөцөд өвс 100.0 тн өвс, 125.0 тн хүчит тэжээл нөөцлөөд байна. Засгийн газрын шийдвэрээр улсын нөөцөөс 820 тн өвс, 667 тн хүчит тэжээлийг малчдад худалдах зөвшөөрлийг олгоод байна.	90.0
		10е.Өвөлжилтийн бэлтгэл ажилд иргэд, малчид, аж ахуйн нэгж, байгууллагын хүч анхаарлыг төвлөрүүлж, орон нутагт зохион байгуулах найр наадмыг хязгаарлах	Өвөлжилтийн бэлтгэл хангах, хадлан тэжээл бэлтгэх талаар бүх сум, баг, байгууллага, мал бүхийн иргэдэд үүрэг чиглэл өгч, 8 дугаар сарын 01-нээс хойш баяр наадам зохион байгуулахгүй байх шийдвэр гаргаж хэрэгжүүлэв.	100.0
27	Мал өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбогдуулан авах нэмэлт арга хэмжээний тухай 2009.09.23 дугаар 296	8а.Өөрийн болон бусад аймгийн нутаг дэвсгэрт мал өвөлжүүлэх, хаваржуулах, арга хэмжээг холбогдох аймаг, сумын удирдлагатай гэрээний үндсэн дээр зохион байгуулж, малчид олноор нүүн нутаглаж байгаа газарт отрын штаб байгуулж ажиллуулан, малчдад хүн, мал эмнэлэг, төрийн бусад үйлчилгээг шуурхай хүргэх болон цаг агаарын сэрэмжлүүлэг, мэдээллээр тухай бүр хангаж ажилласугай.	2009-2010 онд мал өвөлжүүлж, хаваржуулах нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Аймгаас ажлын хэсгүүд томилон Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгийн нутагт мал өвөлжүүлэх гэрээ хэлцэл хийж, эдгээр аймгийн нутагт 265 өрх, 167.7 мянган мал, өөрийн аймгийн сум хооронд болон Дархан цаазат, байгалийн цогцолбор газрууд, хилийн зурвас нутагт 383 өрх, 228.1 мянган мал отроор өвөлжиж байна. Аймаг сумдаас оторчдыг эргэх, хүн мал эмнэлгийн болон бусад үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ авч байна.	100.0

		86.Өвс тэжээлийн хүрэлцээтэй аймаг болон орон нутгийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмж, бүрдүүлэх, өвс, тэжээлийг малчдад худалдан борлуулах арга хэмжээ авсугай.	Улиастай, Тосонцэнгэл, Завханмандал, Тэс сумдад аймгийн нөөцийн өвс 100.0 тн өвс, 125.0 тн хүчит тэжээл байршуулж, сумдын ЗДТГ-аар дамжуулан малчдад олгох арга хэмжээ авч байна. Улсын нөөцийн өвс тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх, Түдэвтэй, Цэцэн-Уул сумдад шэнээр цэг байгуулан өвс тэжээл байршуулах саналыг Онцгой байдлын Ерөнхий газарт хүргүүлээд байна. Улсын нөөцөөс эхний ээлжинд өвс 2530 тн, хүчит тэжээл 840 тн-ыг малчдад худалдан авах захиалга ирүүлээд байна.	90.0
		3.Байгаль орчин		
28	Журам батлах тухай 2007.10.03 дугаар 256	2."Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн журам"-ын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймаг нийслэл сум дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Журмыг сумдад хувиан хүргүүлж, цөлжилтийн зэрэглэл тогтоох судалгааг сумдаас авч нэгтгэлээ.. Элсний нүүдэл, цөлжилттэй тэмцэх талаар төсөл бичиж гадаад дотоодын санхүүжүүлэгч байгууллагуудад хандаж, хөрөнгийн эх үүсвэр хайж байна. БНСУ-ын Хойт Чонг Чун мужийн газар тариалангийн компаний удирдлагууд, эрдэмтдийг урин ирүүлж, говийн бүсийн цөлжилтийг сааруулахад хамтран ажиллах боломжийг газар дээр нь судлуулж, 3 газар туршилтын тариалалт хийсэн нь үр дүнтэй боллоо. 2010 онд 5 га талбайг ургамалжуулах төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. Энэ төсөл хэрэгжих боломжтой бол БНСУ-ын талаас 9.0 мянган ам долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгдөж байгаа юм. Мөн 2009 онд аймгийн хэмжээнд 16.9 мянган мод тариалсан.	70.0
29	Усны экологи, эдийн засгийн үнэлгээ батлах тухай 2008.02.06 дугаар 47	2.Усны нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдол, учирсан хохиролыг үнэлэх, ус ашиглагч, түгээгч, хэрэглэгч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг,хариуцлагыг тодорхойлоход усны экологи-эдийн засгийн үнэлгээг мөрдөж ажиллахыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Усны экологи эдийн засгийн үнэлгээг сумдад хүргүүлж, мөрдөж байна.	100.0
30	Түр журам батлах тухай 2008.02.27 дугаар 72	2."Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, туршилтын журмаар үе шаттайгаар зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг...аймаг сумдын дарга нарт үүрэг болгосугай.	Түр журмыг сумдад хувиан хүргүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Одоогоор тус аймгийн нутагт хувиараа ашигт малтмал эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллага иргэд байхгүй байна.	100.0
31	Ой зохион байгуулалт хийх журам батлах тухай 2008.03.05 дугаар 85	2.Ой зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагын хүчээр хийлгэж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /Ойн нөхөрлөл, ААН, байгууллагад ойг гэрээгээр эзэмшүүлж хамгаалуулах, ашиглуулах/	Ой зохион байгуулах журмыг сумдад хувиан хүргүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Тус аймаг 2008 онд ой зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, дүгнэлт гаргууллаа. Ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 2009 онд шинээр 11 нөхөрлөл байгуулагдаж, нийт 27 ойн нөхөрлөл ажиллаж байна.	100.0

32	Тусгай зориулалтаар 2009 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээ тогтоох тухай 2008.04.18 дугаар 140	3.Ан амьтныг тусгай зориулалтаар агнаж, барьсан зөвшөөрлийн хураамжийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод тооцож, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. /угалз, тэх, хар сүүлтий, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, агнуурын шувуу, хүрэн баавгай, идлэг шонхор шувуу/	Орлогыг хуваарийн дагуу орон нутгийн орлогот төвлөрүүлж ажиллаж байна. 2009 онд агнах бор гөрөөс, гахайн хуваарийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан сумдад хүргүүлж 7 гахай, 5 бор гөрөөс, 10.0 тн загас үйлдвэрлэлийн зориулалтаар агнаж, тусгай зориулалтаар 7 шонхор шувуу барьсан.	100.0
33	Журам батлах тухай 2008.05.28 дугаар 190	2."Ургамалын хорио цээр тогтоосон үед баримтлах журам"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ...бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Журмыг бүх сумдад хувиан хүргүүлж, хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгч, мөрдөж ажиллаж байна.	100.0
34	"Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам" батлах тухай 2009.07.22 дугаар 227	2.Ойн сангийн тодорхой хэсгийг энэхүү журмын дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай	Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журмыг бүх сумдад хувиан хүргүүлж, сурталчилах ажлыг зохион байгуулж байна. 2009 онд 414 га-д ойжуулалтын, 30 га-д нөхөн сэргээх ажлыг хийж, ойн нөхөрлөлүүдэд ойн санг гэрээгээр эзэмшүүлж байна.	70.0
35	Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2009.11.25 дугаар 351	1.Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг хавсралт ёсоор баталсугай. /Ашиг олох зориулалтаар ашигласан усны шоометр тутамд ...Завхан...Гадаргын ус 20 төг, Газрын доорхи ус 40 төг/	Энэ тогтоолыг бүх сум, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад хувиан хүргүүлж ус ашигласны төлбөрийг энэ хэмжээгээр тогтоож байна.	70.0
4.Үйлдвэрлэл, худалдаа, хүнсний хангамж				
36	Бүсийн тулгуур төв хотуудыг 2020 он хүртэл хөгжүүлэх хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай. 2005.09.26 дугаар 201	3.Бүсийн хөгжлийн хөтөлбөр болон тулгуур төв хотын ерөнхий төлөвлөгөөний үндсэн шийдэлтэй уялдуулан ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хотын доторхи хорооллуудын хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг.... холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Батлагдсан ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, Газар зохион байгуулалтын болон Улиастай хотын доторх хэсэгчилсэн төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар хэлэцүүлж батлууллаа.	100.0
37	Хүнсний аюулгүй байдлыг хангах, архи дан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2008.01.04 дугаар 4	1.Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүнсний тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай зэрэг хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг...аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аймгийн нийтийн хоолны газрууд, согтууруулах ундаа болон хүнсний худалдаа эрхлэгчэд мэргэжлийн байгууллагууд хамтран байнгын хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 40/428/07/121/333 тоот дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар 49 цэг салбарын зөвшөөрлийг хүчингүй болголоо. Аймгийн хэмжээнд химийн бодисын тооллого явуулж, дүнг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлсэн.	100.0
		2.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6.4-ийг хэрэгжүүлэх зорилгоор Үйлдвэр, худалдааны яамнаас баталсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тооны нормативийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Үйлдвэр, худалдааны сайдын тушаалаар баталсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тооны нормативийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймагт 2009 онд согтууруулах ундаа худалдаалдаг 145 дэлгүүр, согтууруулах ундаагаар үйлчилдэг 28 зоогийн газар, кафе, баарны үйл ажиллагаанд шалгалт хийж, зөрчил, дутагдалтай ажиллаж байгаа 49 цэг салбарын зөвшөөрлийг Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтийн дагуу хүчингүй болголоо.	100.0

		3.Хүнсний аюулгүй байдлыг хангах, аюулгүй хүнс хэрэглэх, дадал, заншлыг хэвшүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллага, үйлдвэрлэгчдийн холбоодын дэмжлэгийг авч, хамтран ажиллахыг... аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хүнсний үйлдвэр эрхлэгчдэд “Хүнсний бүтээгдэхүүний технологийн заавар боловсруулах, бүтээгдэхүүний орц зохиох, гарцыг тооцох аргачлал” “Хүнсний аюулгүй байдал, сав баглаа боодол” “Бүтээгдэхүүний стандартчилал ба баталгаажуулалт” сэдэвт сургалтууд зохион байгуулж, тогооч нарын дунд ур чадварын уралдаан тогтмол явуулж байна. Талх нарийн боовны цехүүдэд шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авлаа. Аймгийн төвийн захар худалдаалж буй мах сүү, цагаан идээнээс 7 хоног тутам дээш авч, ХХААЖДҮ-ийн газрын ариун цэврийн лабораторид шинжлүүлж, хүнсний аюулгүй байдал, стандартын шаардлагыг ханган ажиллаж байна.	100.0
38	Техникийн зохицуулалтын тухай 2008.04.30 дугаар 159	1.Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалтыг хавсралтын ёсоор баталж, 2008 оны10 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдсүгэй.	Аймагт согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрүүдэд тогтоолыг хувилж хүргүүлэн мөрдөж ажиллаж байна. Аймгийн архины 4 үйлдвэрийн технологичдыг Улаанбаатар хотод “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх” сургалтад хамрууллаа.	100.0
39	Үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2008.05.28 дугаар 191	1.Бизнесийн орчныг сайжруулах талаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хасралтын ёсоор баталсугай.	Төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг холбогдох хэлтэс, агентлаг, байгууллагуудад хүргүүлэн, яам газруудтай гэрээ байгуулж, оны үндсэн чиглэл, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах арга хэмжээ авч байна. Үйлдвэржилтийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөнд энэ талаар заалт оруулж хэрэгжүүллээ. 2009 онд ОХУ-ын Тыва улстай хамтран хилийн худалдааг 2 удаа зохион байгуулж, үйлдвэрлэгчид бизнес эрхлэгчид 1.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, “Эх орны шим-2009” “Арц суурь-2009” “Завхан түншлэл-2009” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Баруун бүсийн түншлэл зах зээлийн өдөрлөг үзэсгэлэн худалдаанд аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчид амжилттай оролцож, 3 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн шалгарч, “Мөнхөд мандаг” ХХК баруун бүсийн шилдгийн шилдэг аж ахуйн нэгж боллоо. Бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 81 төсөлд 780.0 сая төгрөгийн зээл олгосон.	100.0

40	Төлөвлөгөө батлах тухай 2008.06.25 дугаар 265	2.Энэхүү тогтоолоор баталсан төрийн байгууллагад чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 9000 стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг ...нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг...аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай 2.1.Төрийн байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан анхан шатны сургалт зохион байгуулж, гэрчилгээ олгох: в/ Аймгийн ЗДТГ-ын дарга нар /2008-2009 онд/ 2.3.Аймгийн чанарын менежерийн 3 өдрийн сургалт зохион байгуулах /2009 онд/	Стандартчилал, хэмжил зүйн төвөөс “Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 9000 стандартыг хэрэгжүүлэх сургалтыг аймагт зохион байгуулж, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах ажилтнууд, үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийн төлөөлөгчдийг хамруулж, 2008 онд 50 хүнд, 2009 онд 25 хүнд сертификат олголоо. Аймгийн чанарын менежерийн 3 өдрийн сургалтыг 2010 оны 1 дүгээр сард зохион байгуулахаар бэлтгэж байна.	90.0
41	2009 оныг “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил” болгох тухай 2008.12.19 дугаар 62	4.“Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-ийн хүрээнд харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллах, явцыг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор ХХААХҮ-ийн яаманд тайлагнаж байхыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	“Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-ийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, 96.0 хувийн биелэлттэй байна. 2009.02.13-нд жилийн ажлын нээлтийг хийж, “Эх орны шим-2009” худалдааг зохион байгуулсан. 2009.12.19-нд зохион байгуулагдсан “Завхан хөгжил” бизнес форумын үеэр Үйлдвэржүүлэлтийн жилийн ажлын үр дүнг дүгнэж, тайлан мэдээг холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлсэн. Аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ өнгөрсөн оноос 15.6 хувиар өссөн дүнтэй байна.	100.0
42	Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл батлах тухай 2009.6.10 дугаар 178	1.10.Аймагт нутгийн захиргаа, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл бүхий үйлдвэр хөгжүүлэх чиглэл, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах салбар ажлын хэсэг ажиллана. Ажлын хэсгийг аймгийн Засаг дарга буюу Засаг даргын ахлагч ажиллана.	Аймагт үйлдвэрлэл хөгжүүлэх болон үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр ажиллах ажлын хэсгийг Засаг даргын орлогчоор ахлуулан ажиллуулж байна.	100.0
		4.“Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”-ийг хэрэгжүүлэх ажлыг тухайн нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд боломжтой бүхий л хэлбэрээр дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. /Завханд: Шилмэл сүргийн аж ахуй, сүү боловсруулах цех, жимс, жимсгэнэ боловсруулан савлах цех, загас үржүүлгийн аж ахуй, модон эдлэлийн үйлдвэр байгуулах/	Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн хүрээнд тус аймагт тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэрлэлийн 8 салбарыг тэргүүн ээлжинд хөгжүүлэхээр баталсан. Үүнд: Мах, ноос боловсруулах, сүү, сүүн бүтээгдэхүүний, жимс жимсгэний, модон эдлэлийн, барилгын материалын, рашаан савлах, улаан хальст сармиссыг эмийн ургамалын чиглэлээр үйлдвэрлэх . 2009 онд Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлд фермерийн аж ахуй 11, сүү цагаан идээний 4, жимс жимсгэний 2, ноосны чиглэлийн 6, модон эдлэлийн 7, барилгын материалын 6 үйлдвэрийг тус тус хамрууллаа.	70.0
		5.Дэд бүтэц, барилга, хот байгуулалт, газрын харилцаа		
43	Барилга, дэд бүтцийн салбарт авах зарим арга хэмжээний тухай 2007.10.31 дугаар 282	5а.Нийслэл болон аймаг, бүсийн тулгуур төв хот, сум суурин газрын нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг төслийг дэс дараатай боловсруулах	Аймаг сумын төвүүдэд газар хөдлөлтийн нутаг дэвсгэрийн бичил мужлалын зураг төслийг боловсруулах талаар санал авч, судалгаа хийж байна.	70.0

		56.Аймаг нийслэлд ажиллаж байгаа барилга хот байгуулалтын албадын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулан жигдрүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулсан барилга байгууламжийн иж бүрэн зураг төсөл, инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зураг, техникийн баримт бичгийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх аж ахуйн нэгжийн мэдлээс авч, тус албанд шилжүүлж архивлах	Аймагт Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрыг байгуулж, барилгын байгууллагуудыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган ажиллуулж байна. Бүх барилга байгууламжтай холбоотой мэдээллийг төвлөрүүлж, шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн зураг төсөв болон холбогдох техникийн бичиг баримтуудыг бүрдүүлж архивлаж байна.	90.0
		5в.Барилга, авто зам, эрчим хүчний байгууламжийг бүртгэж, паспортжуулах журмыг 2008 онд багтаан шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	Аймгийн хэмжээнд барилгыг паспортжуулах ажил 70 хувьтай байна. Бусад байгууламжуудыг паспортжуулах бүртгэлийн ажил хийгдэж байна.	50.0
44	Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2008.07.09 дугаар 282	1...."Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр улсын хэмжээнд бүрдүүлэх газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, байршил"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор ...баталсугай. /"НИК" ХК Завхан аймгийн Улиастай суманд А-80 944 тн, Дезилийн түлш 991 тн, нийт 1935 тн/	Энэ асуудлаар "НИК" ХК-д санал тавьж, шатахууны нөөц хүрэлцээтэй байна.	100.0
45	Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай 2009.05.14 дугаар 142	1.Аймаг нийслэлийн ИТХ-ын саналыг үндэслэн 2009 онд улсын хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг хавсралт ёсоор баталсугай. Завхан аймаг: Өмчлүүлэх газрын нийт хэмжээ 147.88 га, иргэдэд үнэгүй өмчлүүлэх газрын нийт хэмжээ 143.28 /үүнээс одоо эзэмшиж байгаа 91.73, шинээр өмчлүүлэх 51.55/, аж ахуйн зориулалтаар 4.6 га /үүнээс төмс хүнсний ногооны 2.0 га, газар тариалангийнхаас бусад 2.6 га/	Улиастай суманд 60 иргэнд, Их-Уул суманд 4 иргэнд, Идэр суманд 15 иргэнд нийт 5.99 га газар, Цэцэн-Уул суманд 0.33 га, Тосонцэнгэл суманд 0.35 га газар өмчлүүлээд байна. Бусад сумдад газрын даамал ажилладаггүй, сумдад кадастрын зураг хийгдээгүй зэрэг шалтгаанаар газар өмчлөлийн ажил хангалтгүй хийгдэж байна. Аймгийн дүнгээр 40.0 хувьтай байна.	30.0
46	Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай 2009.07.14 дугаар 213	4.Тухайн орон нутгаас нийслэл болон бусад аймаг, хотын чиглэлд хийх зорчигч тээврийн үйлчилгээг зохицуулах асуудлыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Тээвэр авто замын газарт шилжүүлж, зохицуулалтын орлогыг тус агентлагт төвлөрүүлэхээр тогтоосугай.	Завхан-Улаанбаатар-Завхан чиглэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд Улаанбаатар талаас Хараацайн жигүүр ХХК шалгарч, 7 хоногт 4 удаа дунд оврын автобус явуулж байна. Завхан талаас "Улиастай шинэ эхлэл хоршоо" шалгарч, аймгийн Тээвэр авто замын газартай гэрээ байгуулж, үйлчилгээнд 45 пургон явж, орлогыг төвлөрүүлж байна..	90.0
47	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм батлах тухай 2009.07.08 дугаар 204	2.Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыгаймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх ажлыг орон нутагт өмнөх онд нь багтаан хийлгэж хэвшлээ. Энэ дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	70.0
48	Эрчим хүчний салбарын 2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2009.09.23 дугаар 295	6...."Улиастай эрчим хүч" төрийн өмчит улсын үйлдвэрийн газар...д олгох шаардлагатай байгаа 4 дүгээр хавсралтад заасан татаасын тооцоог хянан 2010 оны улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд С.Баярцогт нарт тус тус даалгасугай. /8480.0 сая төг/	"Улиастай эрчим хүч" төрийн өмчит улсын үйлдвэрийн газарт 2010 оны төсөвт 5.2 тэрбум төгрөг тусгасан байна.	70.0
		6.Эрүүл мэнд, спорт		

49	<p>Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай 2008.03.19 дугаар 111</p>	<p>1.Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлогыг 2008-2015 хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.</p>	<p>Донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган мөрдөж, цус цусан бүтээгдэхүүнийг тасралтгүй үйлдвэрлэж, аюулгүй найдвартай бүтээгдэхүүнээр хангаж байна. “Цус сэлбэлтээр дамжих халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх нь” “Донорын цус цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого” “Цусны аюулгүй байдлыг хангахад лабораторийн шинжилгээний чанарыг сайжруулья” “Цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ” сэдэвт сургалт семинар зохион байгуулж, холбогдох мэргэжилтнүүд, сумдын эмч нарыг оролцууллаа. Аймгийн хэмжээнд 2009 онд 306 донороос 96.6 литр даршилсан цус бэлтгэж, төлөвлөгөөг 120.7 хувиар биелүүллээ. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх хэрэглэх явцад ямар нэгэн урвал хүндрэл, дотоод халдвар гараагүй байна. “Цусны донорын эгнээнд нэгдэцгээе” хөдөлгөөн өрнүүлж, шинээр 174 донор нэмэгдэж, 1106 донортой болоод байна.</p>	100.0
50	<p>Оюутны спортын II их наадам зохион байгуулах тухай 2008.05.28 дугаар 197</p>	<p>1.Оюутны спортын II их наадмыг 2009 онд хамтран зохион байгуулах арга хэмжээ авахыг...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Тус аймагт ажиллаж буй их, дээд сургууль, коллежид хувилан хүргүүлж, хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, тамирчдыг бэлтгэн тэмцээнүүдэд оролцлоо. Баруун бүсийн аймгуудын их дээд сургуулиудын оюутны спортын 12 дугаар их наадмын сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар, даам, теннисний төрлүүдийг аймагтаа зохион байгуулж, Увс, Ховд, Говь-Алтай, Хөвсгөл, Архангай аймгийн болон ОХУ-ын Горный-Алтайн их сургуулийн оюутнууд оролцон энэ үеэр оюутны эрдэм шинжилгээний бага хурал хийлээ. Энэ арга хэмжээнд аймгийн ЗДТГ-аас 1.0 сая төгрөг олгосон.</p>	100.0

51	Нийтийн биеийн тамир спортын талаар авах зарим арга хэмжээний тухай 2009.01.07 дугаар 05	6.1.Иргэд биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулан гүйлт, алхалтын зам, дасгал, хөдөлгөөн, хийх, ногоон байгууламж бүхий ил талбай байгуулж, өвлийн улиралд байгалийн болон хиймэл мөс, цасан талбайг харьяа нутаг дэвсгэрийнхээ орон сууц, гэр хорооллын орчимд байгуулж, тогтмол ажиллуулах	Улиастай сумын 6 багт биеийн тамирын талбай байгуулж, өвлийн спортын бааз ажиллуулан уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулж, аймагт битнес клуб шинээр байгууллаа. Аймгийн хэмжээнд “Биеийн тамир-эрүүл мэнд” уриан дор зохион байгуулах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, бүх сумдад 7 дугаар сарын 3 ны өдөр нэгэн зэрэг нээлтийг хийж, хэрэгжүүлсэн. Мөн аймгийн Засаг даргын нэрэмжит спортын наадмыг үндэсний спортын 7 төрлөөр явуулж тэргүүнүүдийг шалгаруулав. Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан ахмад настны “Спорт-явган аялал” -ыг зохион байгуулсны дээр. Улиастай, Тосонцэнгэл, Ургамал, Завханмандал, Дөрвөлжин, Түдэвтэй, Их-Уул, Сонгино, Цэцэн-Уул, Нөмрөг, Тэс сумд явган аяллыг насны ангиллаар зохион байгуулж, аялал хийх замдаа төрөл бүрийн спортын тэмцээн явуулах, байгалийн үзэсгэлэнт газар үзэх, малчдад туслах, орчны бохирдолыг цэвэрлэх зэрэг ажлыг хийж, тэргүүлсэн баг тамирчдыг урамшуулсан.	100.0
		6.2.Биеийн тамир спортын чигллээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын санаачлагыг бүх талаар дэмжиж ажиллах	Аймагт үндэсний бөхийн, сурын, теннисний, жу-до бөхийн, уулын аялал жуулчлалын холбоод ажиллаж, секц, дугуйлан хичээллүүлж байна. Эдгээр холбоод хамтарч, “Спортын холбоо” ТББ байгуулан төрийн байгууллагуудаас дэмжлэг үзүүлж байна. Монголын хараагүйчүүдийн нийгэмлэгээс зохион байгуулсан Хараагүйчүүдийн улсын аврага шалгаруулах тэмцээнд 6 тамирчныг оролцуулж, зардлыг төрөөс хариуцлаа. Монгол Улсын хөдөлмөрийн баатар Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Спорт эрүүл мэнд-эрүүл байгаль саруул ухаан” сэдэвт явган аяллын багийнхан мянганы замаар 1000 км аялж, аймгийн Засаг даргын нөөц сангаас 500.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Олимпын хөдөлгөөнийг сурталчлах “Олимп-Эв нэгдэл” 40 хүний бүрэлдэхүүнтэй баг тамичид тус аймгийн нутгаар 960 км аялж, 8 суманд уулзалт зохион байгуулж, спортын хэрэглэл материал гардуулсан.. Энэ үеэр Олон улсын Олимпын хорооны хүндэт гишүүн Ш.Магваны алдрын танхимыг аймгийн Алдартны Мүзайд байгуулж, нээлтийг хийлээ.	100.0

		6.3.Аймгийн биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааг идэвхижүүлж, чадавхийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах	Аймгийн Биеийн тамир, спортын хороог газар болгон өргөтгөж, мэргэжилтэн, дасгалжуулагчдыг сургалтанд хамруулж, мэргэжлийг дээшлүүлж, улсын болон бүсийн чанартай уралдаан тэмцээнд тамирчдыг оролцуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. 2009 онд өсвөр үеийн болон залуучуудын улсын аврага шалгаруулах тэмцээнээс 7 алт, 8 мөнгө, 11 хүрэл медаль, 12 шагналт байр авлаа. Газрын дарга, ахлах дасгалжуулагч нар Увс аймагт болсон “Олимп-эв нэгдэл” зөвлөгөөнд оролцлоо.	100.0
		6.4.Сумын соёл-спортын төв, аймгийн спортын ордонд иргэд биеийн тамир спортоор хичээллэх, уралдаан тэмцээн зохион байгуулах таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ авах	Аймгийн Биеийн тамир спортын газрын дэргэдэх бие бялдар чийрэгжүүлэлтийн танхимыг тохижуулж, шинээр баригдсан барилгын өргөтгөлийн хэсэгт амрах өрөө, халуун ус, шүршүүр, хувцас солих өрөө байгуулж, тамирчдад зохиулсан хоолны газар нээлээ.	90.0
		6.5.Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн биеийн тамир, спортын заал, танхим, гадна талбайн ашиглалтыг сайжруулах, цаашид зориулалтыг өөрчлөх, бусдад шилжүүлэх, худалдахыг хориглох чиглэлээр тодорхой арга хэмжээ авах	Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган Биеийн тамир, спортын газрын ордонд өргөтгөл барьж, ашиглалтад орууллаа. Биеийн тамирын зориулалттай байгууламжийг хувьчлах, худалдах үйл ажиллагаа явагдаагүй.	100.0
		7.Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхийг ...бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2009 оны аймгийн төсөвт “Эрүүл мэндийн төлөө хамтдаа” арга хэмжээнд 2.5 сая төгрөг, “Алтан намар-2009” хүүхдийн спортын наадам зохион байгуулахад 2.5 сая төгрөг, аймгийн Засаг даргын нэрэмжит “Хаврын хавар-2009” үндэсний спортын наадам зохион байгуулахад 3.0 сая төгрөг тус тус зарцууллаа.	100.0
52	Үндэсний спортын IY их наадмыг 2010 онд зохион байгуулах тухай 2009.07.14 дугаар 211	1.Монголын үндэсний спортын IY их наадмыг 2010 онд орон даяар зохион байгуулахыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Их наадмыг зохион байгуулах аймгийн комисс, ажлын төлөвлөгөөг Засаг даргын захирамжаар томилон бэлтгэл ажлыг хангаж байна. /Хугацаа болоогүй/	-
		2.Их наадмыг орон нутагтаа зохион байгуулах, шигшээ наадамд оролцох баг, тамирчдын зардлыг төсвийн багцдаа тусгахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	Их наадмыг зохион байгуулахад зориулж, аймгийн 2010 оны төсөвт 1.0 сая төгрөг төлөвлөсөн. Наадмын ерөнхий зардал Биеийн тамир спортын газрын төсөвт тэмцээний төрөл тус бүрээр тусгагдаад байна.	50.0
53	Үндэсний стратегийг сайшаах тухай 2009.07.29 дугаар 239	“Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн зорилт болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхийг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Ажлын байрны дасгал хөдөлгөөний сургалтыг аймагт 2 удаа зохион байгуулж, 60 гаруй хүн оролцлоо. Энэ чиглэлээр 13 сургагч багш бэлтгэгдэж, албан байгууллагуудын ажилтнуудад ажлын байрны дасгал хөдөлгөөн зааж, хийж хэвшлээ. “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” сарын аян зохион байгуулж, дүгнэсэн. Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран “Эх хүүхдийн хоол тэжээл” төслийг аймагт хэрэгжүүлж байна. Аймгийн эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Эрүүл байхын төлөө хамтдаа” бүх нийтийг хамарсан зөв хооллолт-дасгал хөдөлгөөн арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, орон нутгийн төсвөөс 0.5 сая төгрөг зарцуулахаар баталлаа.	70.0
		7.Боловсрол, соёл, шинжлэх ухаан		

54	Журам батлах тухай 2007.12.29 дугаар 359	1.Монгол Улсын шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журмыг хавсралтын ёсоор баталсугай. /2011-2015 онд тодорхойлох арга хэмжээг 2008 онд багтаан хэрэгжүүлэх, 4 жил тутам тодотгол хийх/	Тус аймаг дахь МУИС-ын Эдийн засгийн салбар сургуулийн дэргэд Эрдэм шинжилгээ судалгааны төв байгуулан ажиллуулж, Баруун аймгуудын Эдийн засгийн орчны, Завхан аймаг-жишиг аймаг эдийн засгийн орчны, Завхан аймгийн Боловсон хүчний нөөцийн судалгааг хийлгэж, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлого тодорхойлох үйл явцад тусгаж байна. Цаашид баруун бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах төв болгон өргөжүүлнэ.	70.0
55	Нэрэмжит тэтгэлэгийн журам батлах тухай 2008.02.06 дугаар 46	1."Сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан суралцагчдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам"-ыг баталж, нэрэмжит тэтгэлэгийг 2009.01.01-ний өдрөөс эхлэн олгосугай.	Журмыг аймагт үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн сургуулиудад хувилан хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна.	100.0
56	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт батлах тухай 2008.05.14 дугаар 175	3.Улс аймаг нийслэлийн хамгаалалтанд байх түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, ажиллахыгаймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. Завхан аймагт Улсын хамгаалалтанд байх 6 ширхэг, аймгийн хамгаалалтанд байх 5 ширхэг түүх соёлын дурсгал жагсаалтанд бүртгэгдсэн.	Аймгийн нутаг дэвсгэрт байгаа улсын хамгаалалтад байх 6 ширхэг, орон нутгийн хамгаалалтад байх 5 ширхэг түүх соёлын дурсгалт зүйлийг бүртгэн хамгаалалтад аваад байна Аймгийн Засаг даргын 2008 оны 136 дугаар захирамжаар Соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах аймгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд аймгийн Музей мэргэжлийн байгууллагатай хамтран сумдын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлүүдийг газар дээр нь үзэж бүртгэн, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, орон нутагт хамгаалах талаар зөвлөгөө өгч, сумдын бүртгэл мэдээллийн санг аймгийн Музейд төвлөрүүллээ. Сумдад орон нутаг судлах танхим байгуулан үзэмэртэй болгох ажлыг зохион байгуулж байна.	100.0
57	Зардлын дундаж норматив батлах тухай 2008.07.22 дугаар 294	1.Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 1 дүгээр хавсралт, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид бага дунд боловсрол эзэмшүүлэхэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 2 дугаар хавсралт, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 3 дугаар хавсралт, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус баталж 2009 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдсүгэй.	Холбогдох байгууллага, сургуулиудад хувилан хүргүүлж 2009 оны төсөвт тусган хэрэгжүүлж байна.	100.0

58	Тооллогын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2008.12.24 дугаар 70	1.Соёлын өвийн хадгалалт хамгаалалттай холбоотой дүрэм, журмыг боловсронгуй болгох, түүх, соёлын үнэт зүйлсийг үрэгдүүлсэн албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцон, цаашид хатуу хяналт тавьж ажиллахыг ...аймаг, нийслэл, сумын Засаг даргад даалгасугай.	Музейн тооллогоор дутагдсан үзмэрүүдийн талаар холбогдох хүмүүст хариуцлага тооцож, хууль хяналтын байгууллагаар шалгуулж байна. Энэ тухай БСШУЯ-нд албан бичиг хүргүүлж, цаашид музейн үйл ажиллагаа, дотоод хяналт, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар холбогдох хүмүүст үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Сумдын соёлын төвийн үйл ажиллагаанд аттестатчилал явуулах үзүүлэлтэд соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын асуудлыг тусган дүгнэж, сумдын Музей-техникийн ажилтнуудын дунд сургалт зохион байгууллаа.	90.0
59	Ой тэмдэглэх тухай 2009.09.02 дугаар 269	2.Монголын үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгч, Хотгойдын шадар ван Чингүнжавын мэндэлсний 300 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах хороог хавсралт ёсоор баталсугай. Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Орлогч дарга-Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав Гишүүд: -...Завхан аймгийн Засаг дарга Я.Санжмятав	Ажлын хэсэг байгуулж, холбогдох хүмүүстэй мэдээлэл солилцож, зохион байгуулах ажлын чиглэлийг боловсруулаад байна.	50.0
8.Нийгэм хамгаалал				
60	Ахмад дайчдын орон сууцны тухай 2007.09.28 дугаар 250	3.Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох гэрээ байгуулахдаа орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож, тусгай санд шилжүүлэх нөхцлийг тусган уг асуудлыг журмын дагуу шийдвэрлэж байхыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Энэ журмыг мөрдөн ажиллах талаар Сумдын Засаг дарга нар, Улиастай сумын захирагч, Газрын албанд үүрэг чиглэл өгч, орон нутагт тусгай сан байгуулах журам гаргахаар шийдвэрлэсэн. 2008 онд ахмад дайчин 4 өндөр настанд гэр олголоо. Энэ тогтоол Засгийн газрын 2008.12.24-ний өдрийн 72 дугаар тогтоолын хүрээнд бүрэн хэрэгжих боломжтой.	100.0
61	Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухай 2008.03.12 дугаар 93	2.Монгол Улсын эдийн засаг-нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудыг оролцуулах нөхцөл бүрэлдүүлж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах асуудлыг 2009 оны үндсэн чиглэлд тусгаж, 13.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Аймгийн эмэгтэйчүүдийн Төрийн бус байгууллагуудын “Өрнөх хөгжил” сүлжээтэй гэрээ байгуулан нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт гаргуулан холбогдох материалыг Хууль зүйн яаманд хүргүүлсэн. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Төр-иргэний нийгмийн түншлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр 8 арга хэмжээ тусгагдсан.	90.0
62	Журам батлах тухай 2008.12.24 дугаар 72	3."Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц эсхүл түүнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн тусламж олгох журам"-ын дагуу хүсэлт гаргасан ахмад дайчныг орон сууцаар хангах, мөнгөн тусламж олгох арга хэмжээ авахыг... аймаг нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аймгийн хэмжээнд 1939 оны дайнд оролцсон 1, 1945 оны дайнд оролцсон 30 хүн, 1940-1948 оны баруун хилийн тулгаралтад оролцсон 14, бүгд 45 ахмад дайчны судалгааг гаргаж, холбогдох материалыг бүрдүүлэн БХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газарт хүргүүлэв. 1939 оны дайнд оролцсон Ц.Ган-Очирт 35.0 сая төгрөг олгосон. Бусад ахмад дайчдад Засгийн газрын чиглэлийн дагуу ээлж дараатай олгох болно.	70.0

63	Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2009.1.28 дугаар 26	2.Бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхий менежер нарт үүрэг болгосугай. /Аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ аймагт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар байна./	Аймгийн хэмжээнд 25-аас дээш орон тоотой 68 байгууллагад 146 хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэн ажиллах судалгаа гарч, байгууллага бүрд тоог тогтоож өглөө. Одоо 47 байгууллагад 75 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Бусад байгууллагуудад аймгийн Засаг даргын албан бичиг хүргүүлж, хэрэгжүүлэх үүрэг өгч, 6 байгууллагад 2.3 сая төгрөгийн төлбөр тавьж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлээд байна. Сумдын Халамжийн асуудал эрхэлсэн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод энэ асуудлыг оруулж, үр дүнгийн гэрээнд тусгалаа.	70.0
64	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2009.04.15 дугаар 113	2.Засгийн газрын 2006 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан ажиллах байгууллагууд”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. Аймгийн ЗДТГ хариуцан гүйцэтгэх зорилт: Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Аймгийн ИТХ-д 9, сумдын ИТХ-д 127 эмэгтэй төлөөлөгч сонгогдон Сумын Засаг даргаар 2, орлогч даргаар 2, ИТХ-ын даргаар 4 эмэгтэй ажиллаж байна. Эмэгтэйчүүдийн санал хүсэлтийг сонсож, бодлого боловсруулахдаа тусгах зорилгоор аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд малчин эмэгтэйчүүдийн чуулган, баруун бүсийн эмэгтэйчүүдийн төлөөлөгчдийн уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөв.	100.0
65	Барилгын салбарт мэргэжилтэй ажилчин бэлтгэх зарим арга хэмжээний тухай 2009.01.28 дугаар 23	5.“100 мянган орон сууц”-ны төслийн хүрээнд мэргэжилтэй ажилчин бэлтгэх төлөвлөгөөг жил бүр шинэчлэн баталж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөв тусгай зориулалтын сан, зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. /Төлөвлөгөөний 3 дахь заалт: Ажилгүй болон ажил идэвхитэй хайж байгаа иргэд, хугацаат цэргийн албан хаагчдыг барилгын салбарын мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж ажиллах/	2009 он гараад аймгийн хэмжээнд түр сургалтад өрөгч угсрагч 25, сантехникч 31 хүн, барилгын цахилгаанчин 10 хүн, засал чимэглэлийн мэргэжилтэн 30 хүнийг суралцуулж, сертификат олголоо. Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг барилгын мэргэжлээр 40 хүн, цахилгаанчин 22 хүн төгсөж, 2009-2010 оны хичээлийн жилд 113 хүүхдийг энэ мэргэжлээр элсүүлээд байна.	90.0
66	Ажлын байрны аттестатчиллын дүнгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2009.04.22 дугаар 122	3.1.Аттестатчилалд амжилттай сайн дүн үзүүлсэн байгууллага, хамт олны туршлага, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаархи шинэ санаачлага, ажлын зөв эхлэлийг нийтийн хүртээл болгох	Ажлын байрны аттестатчилалд 433 аж ахуй нэгж байгууллага хамрагдсанаас 65 нь хангалтгүй, 58 нь сайн үнэлгээ авсанаас 40 байгууллагад батламж олгож, урамшуулсан. Эдгээр байгууллагын ажлын арга барил, орчныг сурталчилж, нийтийн хүртээл болгож байна. Аймагт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог ҮЭХолбоо, Ажил олгогч эздийн холбоо, Төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан шинээр байгуулан ажлын төлөвлөгөөг боловсруулаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай асуудлыг сумдын ЗДТГ-ын нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод оруулж, үр дүнгийн гэрээнд тусган ажиллаж байна.	70.0

		3.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн түншлэлийн талууд, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах	2009 онд аймгийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газраас дээрх салбар хороотой хамтран улирлын чанартай ажилладаг уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг байгууллагуудад нөхөн аттестатчилал явуулж байна. 2009 онд бүх барилгын салбаруудыг хамрууллаа. Аттестатчилалд хангалтгүй дүн үзүүлсэн байгууллагуудад дахин шалгалт хийхээр төлөвлөж, 5 барилгын компанид дахин аттестатчилалд явуулаад байна.	70.0
		3.3.Аймгийн төрийн байгууллага, орон сууцны халаалтыг нэгдсэн системд шат дараатайгаар оруулах, нам даралтын зуухны тоог цөөрүүлэх, тэдгээрт ажиллагсдын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах	Тус аймгийн төвд тусгай зөвшөөрөлтэй 13 халаалтын зуух болон 31 нам даралтын зуухнууд ажиллаж, албан байгууллага, айл өрхүүдийг халааж байна. Эдгээрийн тоог цөөрүүлэх, аймагт Дулааны үйлдвэр байгуулах талаар УИХ-ын гишүүд, Засгийн газар, холбогдох яамдад саналаа удаа дараа хүргүүлсээр байна.	50.0
		3.4.Зураг төсөл нь хянагдаагүй, хориотой бүс, зөвшөөрөлгүй газарт барилга байгууламж шинээр барих явдлыг таслан зогсоох, нэг хүнд ноогдох ажлын байрны талбайн хэмжээ, барилга байгууламжийн чанар, стандартын хэрэгжилтэд орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагаас тавих хяналтыг сайжруулах	Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй объектуудад шалгалт хийхэд зураг төсөл нь хянагдаагүй болон зөвшөөрөлгүй газарт барилга байгууламж баригдсан зөрчил гараагүй байна. Хувийн хэвшлийн байгууллагуудын барьж буй барилгуудад хяналтын хэсэг томилон шалгалт хийлээ.	100.0
		9.Төрийн захиргааны удирдлага		
67	Журам батлах тухай 2006.03.22 дугаар 51	1.Яам болон аймаг нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмыг хавсралт ёсоор баталсугай	Энэхүү журмын дагуу аймгийн Засаг даргын 2008 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүнг ЗГХЭГ-т 2009.3.9-ний өдрийн 26/179 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүнд: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 96.1 хувь, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр 65.2 хувь, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт 90.82 хувь, Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламж 100.0, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 97.6, яамдын сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 89.0 хувь, эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ 98.2 хувь, хэрэглэгчийн үнэлгээ 92.2 хувийн биелэлттэй, ерөнхий үнэлгээ 90.2 хувь байна.	100.0
		2.Засгийн газрын агентлаг, сум дүүргийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмыг баталж, мөрдүүлэхийг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн хэмжээнд сум, баг, хэлтэс, агентлагуудын ажлыг дүгнэх журмыг аймгийн Засаг даргын 2009 оны 85 дугаар тогтоолоор шинэчлэн баталж хэрэгжүүлж байна.	100.0
68	Журам батлах тухай 2006.07.05 дугаар 160	1.“Хууль тогтоомж ,Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам ”-ыг хавсралт ёсоор баталсугай.	Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг журмын дагуу зохион байгуулж, үр дүн биелэлтийг дүгнэн Улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээлж байна. 2009 оны IV улиралын байдлаар 120 шийдвэрийн 183 заалтыг хяналтад авч хэрэгжилт 91.44 хувьтай байна.	100.0

69	Сургалт семинарын зохион байгуулалтыг сайжруулах тухай 2008.11.12 дугаар 32	За.Сургалт, семинарын нэгдсэн хуваарийн биелэлтэд байнга хяналт тавьж, төлөвлөгдсөн арга хэмжээнд ажилтнуудаа оролцуулан, тэдгээрийн томилолтын тайлан, үр дүнг тогтмол дүгнэж байх	2009 онд төвийн болон орон нутгийн сургалтад төрийн албан хаагчдыг хамруулах төлөвлөгөө батлан хэрэгжүүлээ. Сумдын шинэр сонгогдсон ИТХ-ын дарга, Засаг дарга нар, аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасгийн дарга, мэргэжилтнүүдийг Засгийн газраас зохион байгуулсан төвийн болон бүсийн сургалтад хуваарийн дагуу хамрууллаа. Орон нутагт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, Конрад Аденуар сан, Ногоон алт хөтөлбөрийн газартай хамтран сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн Засаг дарга нарт 6 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 314 хүн оролцсон. Сумдын ЗДТГ-ын мэргэжилтнүүдийг аймгийн ЗДТГ болон харьяа агентлагуудаас зохион байгуулсан сургалтад бүрэн хамруулсан. Удирдлагын академийн Засгийн газрын тэтгэлэгт Төрийн удирдлагын менежерийн ангид 2, төлбөртэй ангид 2, Нийгмийн удирдлагын төлбөртэй ангид 2, Бизнесийн удирдлагын төлбөртэй ангид 2, Богино хугацааны сертификаттай сургалтад 2 хүнийг тус тус элсүүлэн суралцуулж байна.	100.0
		Зб.Гадаад оронд зохион байгуулагдах сургалт, семинарт оролцохдоо ЗГХЭГ-аас зөвшөөрөл авч, томилолтоор ажилласан дүнгээ тайлагнаж, өөр аймаг, нийслэлд ажиллахдаа тухай бүр мэдэгдэж байх	2009 онд аймгийн Төрийн захиргааны байгууллагуудаас БНХАУ, Герман, Польш, Энэтхэг Солонгос улсад зарим албан хаагчдыг сургалтад хамруулж, тус аймагтай ах дүүгийн найрамдалт харилцаатай Солонгос улсын Сосан хотын төр захиргааны байгууллагад 2 албан хаагчийг 1 сарын хугацаатай дадлагажуулсан.	100.0
		Зв.Сумын Засаг дарга, ЗДТГ-ын болон төсвийн бусад байгууллагын ажилтнуудын дотоод, гадаад албан томилолтын жилийн хуваарийг батлан мөрдүүлж, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд томилолт олгохгүй байх	Албан томилотын зардлын хуваарийг сар, улирлаар төлөвлөн хуваарилж байна. Сумдын ЗДТГ-аас гадаад томилолтын зардал гараагүй.	100.0
70	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2009.01.07 дугаар 01	2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хугацаанд нь шуурхай хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллан хэрэгжилтийн явцад жил бүрийн 6, 12 дугаар сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус аймагтай холбоотой 170 арга хэмжээ тусгагдсаныг хяналтад авч, салбар нэгжүүдэд хувилан хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.	50.0
71	Төлөвлөгөө батлах тухай 2009.01.07 дугаар 02	2.Моногл Улсын эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг оны эхнээс эрчимтэй хэрэгжүүлж, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тус аймагтай холбоотой 8 асуудал тусгагдсаныг хяналтад авч, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Биелэлт 94.0 хувьтай.	90.0
72	Журам шинэчлэн батлах тухай 2009.01.07 дугаар 3	1."Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам"-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.	Журмыг холбогдох хүмүүст танилцуулж, Засаг даргын зөвлөлийн хурлын хуралдааны журмыг боловсруулахад удирдлага болголоо.	100.0

73	Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай 2009.01.14 дугаар 13	2.Сумын ЗДТГ-ын зохион байгуулалтын бүтцийн талаар санал боловсруулан ЗГХЭГ-тай зөвшилцсөний үндсэн дээр энэ оны 1 дүгээр сард багтаан баталж, мөрдүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Тус аймгийн Завханмандал, Асгат сумд 1500 хүртэл, Алдархаан, Отгон, Тэс сумд 3001-5000, Их-Уул, Тосонцэнгэл сумд 5001-10000, Улиастай сум 10001-ээс дээш, бусад 16 сум 1501-3000 хүн амтай бөгөөд энэ тогтоолын дагуу тооцож үзэхэд сумдад 23 орон тоо буюу 79.3 сая төгрөг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэ тухай саналаа Засгийн газарт болон холбогдох яамдад хүргүүлсэн.	90.0
74	Ажлын өдөр шилжүүлэх тухай 2009.02.18 дугаар 55	1.2009 оны 2 дугаар сарын 27-ны баасан гаригийн ажлын өдрийг 3 дугаар сарын 1-ний ням гаригийн амралтын өдөрт шилжүүлсүгэй.	Сум, албан байгууллагуудад хүргүүлж, аймгийн хэмжээнд ажлын өдрийг шилжүүлж ажилласан .	100.0
75	Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай 2009.05.14 дугаар 143	2./Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт/ -ийг хангах арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. Үүнд:1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал. 2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал 3.Төсөв, санхүүгийн ил тод байдал 4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	1.Төрийн захиргааны байгууллага, албан хаагчид үйл ажиллагааны эрхэм зорилго, зорилт, ажлын байрны чиг үүрэг, өрөө тасалгааны болон утасны дугаараа ил тод байрлуулан төрийн болон үйлчилгээний байгууллагуудын ажлын тайланг иргэдэд улирал тутам танилцуулж байна. Төрийн бүх шатны байгууллага, албан хаагчид сар бүрийн тогтмол нэг өдрийг “Нээлттэй өдөр” болгон ажиллаж байна. Засгийн газрын 2007 оны 190 дугаар тогтоолын дагуу “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, иргэдээс 777 санал хүлээн авч, хэрэгжүүлж байна. 2.Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг ил тод, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр зарлан 2 удаа зохион байгуулж, эхний ээлжинд 76 ажлын байранд 499 хүн шалгалтад орсноос 68 нь тэнцэж төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэгдэн эдгээрээс 42 нь ажлын байраар хангагдаад байна. 2 дахь шалгалтыг 12 дугаар сарын 19-нд зохион байгуулж, 242 хүн шалгалтад орж, 92 нь тэнцсэн дүнтэй байна. Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 12 сумын ЗДТГ-ын дарга, 8 хэлтэс агентлагийн дарга, 9 сургуулийн захирал, 12 цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын байранд явуулж 128 хүн орсноос тухайн ажлын байрны шаардлагыг хангасан хүмүүсийн томилон ажиллуулж байна. 3.Төсөвт байгууллагуудын батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, санхүүгийн аливаа зөрчилд авагдсан арга хэмжээ, хариуцлага тооцсон байдал зэргийг байгууллагын мэдээллийн самбар, орон нутгийн сонин, телевизээр тогтмол мэдээллэж байна. 4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй 4 объектын тендерийг нээлттэй зарлаж, урилгыг Сангийн яамны ВЕБ сайтад тавьж, Үнэн, Өдрийн сонинд нийтэлж, гүйцэтгэгчийг шалгаруулан ажлыг гүйцэтгэсэн.	70.0

76	Журам батлах тухай 2009.06.03 дугаар 164	1."Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай	Журмыг бүх сумдын ЗДТГ болон төрийн захиргааны байгууллагуудад хувиан хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.	100.0
		3.Санхүү, эдийн засгийн хүндрэлтэй холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 24.1.1-д заасан насанд хүрсэн төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь саналыг харгалзан үргэлжлүүлэн ажиллуулах, төрийн албанаас чөлөөлөх дараалал тогтоох замаар төсөвт хэт ачаалал үүсгэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхий менежер нарт даалгасугай.	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч үүссэн 41 төрийн албан хаагч нэг удаагийн буцалтгүй тусламж авах саналаа ирүүлснээс дараалал тогтоож, эхний 13 хүнд олгохоор 2010 оны төсөвт суулгаж, материалыг Сангийн яаманд бүрдүүлж хүргүүлээ.	70.0
77	Болзол батлах тухай 2009.07.01 дугаар 193	1."Улсын тэргүүний /загвар/ сум шалгаруулах болзол"-ыг хавсралт ёсоор баталсугай. /2 жил тутамд шалгаруулна/	Болзлыг бүх сумдад хувиан хүргүүлж, сурталчилж байна. Сумдын ажил дүгнэх үзүүлэлтүүдийг аймгийн Засаг даргын 2009 оны 185 дугаар захирамжаар шинэчлэн баталж, болзолд заасан үзүүлэлтүүдийг журамд бүрэн оруулж, 2009 оны ажлыг дүгнэх бэлтгэлийг хангаад байна.	70.0
78	Журамд нэмэлт оруулах тухай 2009.09.16 дугаар 285	4.17.Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн удирдлага, зохицуулалт болон үр дүн, биелэлтэд нь хяналт тавьж, явц, дүнд хяналт шинжилгээ хийж, хэрэгжилтийн үр дүн, мэдээг энэхүү журмын 5, 6, 7 дугаар хавсралт ёсоор гарган, хагас жилийн дүнг 8 дугаар сарын 20-ны дотор, бүтэн жилийн дүнг дараа оны 4 дүгээр сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Журмыг холбогдох газруудад хувиан хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Хөтөлбөрүүдийн биелэлтийг гаргаж, 2009 оны 3. 7 дугаар саруудад Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	90.0
		4.20.Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн байдал, үр дүн, явцын талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх, жилийн эцсийн дүнг дэлгэрэнгүй тайлантай хамт ирүүлнэ.	Хөтөлбөрүүдийн биелэлтийн 2009 оны дэлгэрэнгүй тайланг энэ журмын дагуу гаргаж байна.	70.0
		10.Хууль, хяналт		
79	Иргэний бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2007.05.23 дугаар 129	2.Сумдад иргэний бүртгэл хариуцан ажиллах, орон тооны ажилтныг ажлын байр шаардлагатай техник хэрэгслэлээр ханган, цаашид иргэний бүртгэл хариуцсан орон тооны ажилтныг сум бүрт ажиллуулах зардлыг нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Орон нутгийн орлогоос санхүүжүүлж, сум бүрт иргэний бүртгэл хариуцсан ажилтан орон тоогоор ажиллуулж, шаардлагатай техник хэрэгслэлээр ээлж дараатай хангах арга хэмжээг авч байна. Сумдын Иргэний бүртгэл мэдээллийн ажилтнуудын сургалт семинарыг 2009 онд 2 удаа зохион байгууллаа.	100.0
80	Шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай 2007.10.17 дугаар 270	1.Аймгийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, аймгийн нэгдсэн эмнэлгийн шүүх-шинжээч эмч нарыг нэгтгэн аймгийн Шүүхийн шинжилгээний алба...байгуулсугай.	Аймагт Шүүхийн шинжилгээний албыг байгуулж, Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн захирлын тушаалаар дарга, ня-бо, шинжээч, шинжээч эмч, гарын мөрний санч, үйлчлэгч, Тосонцэнгэл суманд криминалистикийн шинжээч, шинжээч эмч нарыг томилон ажиллуулж байна.	100.0

		2.Дээрх байгууллагуудын криминалистикийн шинжээч, шүүх-шинжээч эмч, шинжээч эмч нарын орон тоо, төсөв болон криминалистикийн шинжээчдийн эзэмшиж, ашиглаж байгаа шинжилгээний аппарат, тоног төхөөрөмжийг тус тус балансаас балансад 12 дугаар сарын 1-ний дотор багтаан Шүүхийн шинжилгээний албанд шилжүүлж, тухайн аймгийн цагдаагийн газар хэлтсийн криминалистикийн лаборатори, ажлын контор, нэгдсэн эмнэлгийн задлан шинжилгээ, цогцос хадгалах өрөөг Шүүхийн шинжилгээний албыг ажлын байртай болох хүртэл төлбөргүй эзэмшүүлж байхыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн Цагдаагийн газарт байгаа криминалистикийн шинжилгээний багаж, тонтог төхөөрөмж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн задлан шинжилгээ, цогцос хадгалах өрөө, бусад материалыг бүртгэж, Шүүхийн шинжилгээний албанд шилжүүлж, аймгийн Цагдаагийн газрын байранд байрлуулж байна.	100.0
81	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай. 2007.12.26 дугаар 346	5.Орон сууцны урт хугацааны зээлд үе шаттайгаар хамруулан цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулах, "40000 айлын орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд шинээр барих орон сууцны хороолол. Бичил хэсгүүдийн зураг төсөвт цагдаагийн хэлтэс тасгийн албан байр, ажиллагсдын орон сууцыг тусгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг ... аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн Цагдаагийн газар нь 12 айлын орон сууцтай. Хилийн цэргийн 0277дугаар анги 8 айлын орон сууц барьж байна. 40000 орон сууц хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвд 30, 20 айлын, зарим сумдад 8 айлын орон сууц баригдаж байгаа бөгөөд ашиглалтад орох үед цагдаагийн байгууллагын 2 ажилтанд байр хувиарлахаар шийдвэрлээд байна.	70.0
82	Архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх талаарх төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх тухай 2008.06.11 дугаар 238	2."Архидалт мансуурлын эсрэг ассоциаци" төрийн бус байгууллагыг сургалт, сурталчилгаа явуулах, цуглаан хийх байраар тухай бүр хангаж байхыг аймаг нийслэл сум дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	Сургалт сурталчилгаа явуулах байрыг аймгийн ГХУСАЗЗөвлөлд шилжүүлж, эд хогшил, компьютер, тоног төхөөрөмжөөр хангалаа. ХЗДХЯ-ны дэргэдэх "АА төв" төрийн бус байгууллагатай хамтран насанд хүрээгүй этгээдийн архидан согтуурахтай тэмцэх асуудлаар Ерөнхий боловсролын сургуулиудын 80 багш, 180 орчим сурагчдаас судалгаа авч, холбогдох байгууллагад хүргүүллээ.	100.0
83	Журам батлах тухай 2009.01.28 дугаар 28	2.Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцос оршуулах журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусган шийдвэрлэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймагт Шүүхийн шинжилгээний алба байгуулагдаж, үйл ажиллагааны үүрэг чиглэлд нь энэ асуудлыг хамруулж байна. Аймагт хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй цогцос гараагүй байна.	100.0

84	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2009.11.04 дугаар 333	2.Томуугийн А хүрээний /H1N1/ вирусийн халдварын эрсдлийг бууруулах зорилгоор дэлгүүр, нийтийн хоол, баар, рестораны үйлчилгээг 21.00 цагаас хойш, олон нийтийг хамарсан хурал, зөвлөгөөн, соёл урлагийн арга хэмжээг...2009 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаагаар зогсоож, халдвартай тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэхийг аймаг нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт даалгасугай.	Манай Улсад томуугийн А хүрээний /H1N1/ вирусын халдвар гарсантай холбогдуулж, аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан “Шуурхай бүлэг” байгуулан ажлын төлөвлөгөө гаргаж, бүлгийн гишүүдийн үүрэг чиглэлийг баталж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Энэ тогтоолын дагуу “Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын захирамж гарч, Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Тээвэр, авто замын газар, Онцгой байдлын хэлтэс, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, албан байгууллагын дарга, орон нутгийн хэвлэл мэдээллийн албаны дарга нарт тус тусад нь тодорхой үүргийг даалгалаа. Аймгийн хэмжээний бүх цэцэрлэгийн үйл ажиллагаанд 11 дүгээр сарын 05-ны өдрөөс тодохойгүй хугацаагаар хорио цээрийн дэглэм тогтоож ажилласан. Улиастайд 3, Тэс суманд 10 гаруй хүн томуугийн А хүрээний /H1N1/ вирусын халдвар авсан нь лабораторийн шинжилгээгээр батлагдаж, тусгаарлан эмчилж эдгэрүүлсэн. Энэ тогтоол Засгийн газрын 2009.11.18-ний өдрийн 343 дугаар тогтоолын 9 дүгээр заалтаар хүчингүй болсон.	100.0
85	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах, авсан зарим арга хэмжээг өөрчлөх тухай 2009.11.18 дугаар 343	2.Нийтийн хоол, баар, рестораныг 21.00 цагаас хойшажиллуулахгүй байх, олон нийтийг хамарсан хурал зөвлөгөөн, соёл урлаг, спортын арга хэмжээг зогсоосныг хэвээр мөрдөж, эрүүл ахуй, ариун цэвэр, халвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт даалгасугай.	Энэ тогтоолын дагуу “Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын захирамжаар тогтоосон хорио цээрийн дэглэмийг сунгаж, мөрдөж ажиллаа. Засгийн газрын 2009.12.02-ний өдрийн 356 дугаар тогтоолоор хүчингүй болсон.	100.0
86	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг бууруулах тухай 2009.12.02 дугаар 356	3.Вирусын халдварын тархалт бүрэн зогсоогүй байгаатай холбогдуулан нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд халдварын тархалтын байдалд хяналт тавьж холбогдох арга хэмжээг шуурхай авч, байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүлийн түвшинд эрүүл ахуй, ариун цэвэр, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж ажиллахыг бүх шатны Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт даалгасугай.	Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан “Шуурхай бүлэг”-ийн бэлэн байдлыг хангаж, төлөвлөгөөний дагуу ажиллуулж байна. Тосонцэнгэл суманд вирусын халдвараар 1 хүн өвчилж нас барж, энд холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллаж байна.	90.0
11.Батлан хамгаалах				

87	Ой тэмдэглэх тухай 200.62.27 дугаар 272	2.Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойд бэлтгэх, зохион байгуулах хороог 1 дүгээр хавсралт, ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.	Ойд бэлтгэх ажлын төлөвлөгөөг аймгийн Ахмадын хороотой хамтран гаргаж, үе шаттай хэрэгжүүлж, ойг тэмдэглэн өнгөрүүллээ. Дайн, байлдаан, тулгаралтад оролцсон болон фронтод бэлгийн цуваа хүргэх ажилд оролцсон хүмүүсийн судалгааг гаргалаа. Аймгийн хэмжээнд 47 ахмад дайчин байна. Эдгээр ахмад дайчдад Халх голын ялалтын 70 жилийн ойг тохиолдуулан аймгийн Засаг даргын мэндчилгээ, дурсамж хүргүүлж, хүндэтгэл үзүүллээ. Ахмад дайчин Д.Доржгочоогийн буланг аймгийн Алдартны музейд байгуулж, Монгол Улсын баатар, армийн генерал Б.Доржийн хөшөөг аймгийн төв талбайд босгож нээлтийг хийлээ.	100.0
88	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2009.02.18 дугаар 56	2...мөнгөн төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2 сая 300 мян төг/	2009 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр 107 иргэн хаахаар аймгийн Засаг даргын шийдвэр гарч, төлбөрийн барагдуулалт 48.0 хувьтай байна.	50.0
89	Тооны дээд хязгаар тогтоох тухай 2009.02.18 дугаар 57	2.Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах арга хэмжээ авч ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. /Завхан 30/	2009 онд аймгийн Засаг даргын захирамжаар цэргийн дүйцүүлэх албыг 23 иргэн 2 дахь жилдээ, 30 иргэн анхны жилдээ хааж байна. Дүйцүүлэх албаны дайчдад цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг 7-14 хоногоор 2 удаа орон нутагт зохион байгуулж, улсын баатар Б.Доржийн хөшөөг байрлуулах талбайг тохижуулахад 84 цаг ажиллуулсан ба бусад бүтээн байгуулалтын ажилд дайчлан оролцуулж байна.	100.0
90	Жагсаалт батлах тухай 2009.08.12 дугаар 246	1.Эмч багш нарыг цэргийн дүйцүүлэх алба хаасанд тооцох алслагдсан сумдын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай. /Завхан аймгийн Асгат, Сантмаргац, Дөрвөлжин, Түдэвтэй, Ургамал, Завханмандал, Сонгино, Баянхайрхан, Тэс, Цэцэн-Уул/	Эдгээр сумдад ажиллаж байгаа, цэргийн алба хаах насны эмч, багш нарын судалгааг гаргахад 2009 оны байдлаар Асгатад 2, Баянтэсд 1, Баянхайрханд 1 хүн ажиллаж байна. Эдгээр хүмүүстэй гэрээ байгуулаад байна.	100.0
Хоёр. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ				
1.Үйлдвэр, худалдаа, хүнсний хангамж,				
1	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай 2009.09.02 дугаар 56	1.2.Жижиг, дунд үйлдвэрийн бэлэн болсон төсөл шалгаруулах ажлыг шуурхай зохион байгуулан, зээл олгох асуудлыг хүндрэл багатай болгох талаар банктай тохиролцож, ажиллах үүргийг аймаг нийслэлийн дэд комисст өгч, уг ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар хөнгөлөлттэй зээл олгох дэд комиссыг аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулж, нийт 171 төсөл хлээн авч, 105 төслийг шалгаруулан 958.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэж, Шуудан банкинд шилжүүлсэн. Одоогийн байдлаар 81 төсөлд 780.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 2009-2010 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж байна.	70.0
2.Дэд бүтэц, барилга, хот байгуулалт				

2	Завхан, Говь-Алтай аймгийн эрчим хүчний хангамжийн тухай 2009.10.7 дугаар 63	1.Завхан, Говь-Алтай аймгийн хэрэглэгчдийг эрчим хүчээр найдвартай хангах бодлогоо оновчтой тодохойлон түүнийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын арга, хэлбэрийн талаар санал боловсруулан ойрын хугацаанд Засгийн газарт оруулахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгав.	Завхан, Говь-Алтай аймгийн хэрэглэгчдийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангахад зориулж, Могойн голын уурхайд Дулааны цахилгаан станц барьж, 2011 оны 3 дугаар улиралд ашиглалтад оруулахаар шийдвэрлэлээ. Дулааны цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, Тэлмэн-Могойг голын чиглэлийн 110 Кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцыг барихад зориулж, 2010 оны төсөвт 1.0 тэрбум төгрөг тусгагдсан.	100.0
3.Байгаль орчин				
3	Химийн хорт бодисоор бохирдсон шлам, ул хөрсийг саармагжуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2009.03.11 дугаар 16	2.5.Цаашид химийн бодисын хууль бус хэрэглээг таслан зогсоох, байгаль орчинд дахин бохирдол үүсгэхгүй байх талаар санаачлагатай ажиллан, буруутай этгээдтэй хариуцлага тооцож ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгов.	Химийн бодисын тооллого явуулж, Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал дүгнэлт гаргах аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж ажиллаж байна. Тус аймагт уул уурхайн ашиглалт хийгдээгүй байгаа тул химийн бодисын хууль бус хэрэглээ одоогоор байхгүй.	100.0
4	Химийн хорт бодисоор бохирдсон шлам, ул хөрсийг саармагжуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2009.03.11 дугаар 16	2.1.Засгийн газрын 2008 оны 72 дугаар тогтоолоор баталсан "Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	Түр журмыг сумдад хувиран хүргүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Одоогоор тус аймгийн нутагт хувиараа ашигт малтмал эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллага иргэд байхгүй байна.	100.0
4.Хууль хяналт				
5	Цаг агаарын аюултай үзэгдлийн талаар 2009.06.24 дугаар 41	7.4.Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн тухай сэрэмжлүүлэх мэдээг баг, хот айл, малчдад хүргэх, мэдээллийн шуурхай байдлыг хангаж, гамшгаас урьдчилан сэргийлэх, учирч болох эрсдэл, хохиролыг бууруулах ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт даалгав.	Аймгийн Онцгой комиссоос "Байгалийн аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх тухай" "Тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөнд хяналт тавьж зохицуулах, холбоо мэдээллийн бэлэн байдлыг хангах тухай" албан мэдэгдлүүдийг гаргаж, холбогдох байгууллага, сумдад хүргүүлж, сэрэмжлүүлэг мэдээг иргэдэд хэвлэл, мэдээллийн хэрэгслэл, олон нийт цуглардаг захын радио узелиудээр нэвтрүүлж, Онцгой комиссын гишүүдийн хаягийн бүртгэл, түргэн цугларалтын схемд тодотгол хийлээ. Аймгийн Онцгой комиссоос 16 удаа мэдээлэл дамжуулсан ба зарим тохиолдолд үүрэн утасны сүлжээг ашиглалаа. Сумаас багт болон малчдад мэдээлэл дамжуулахад холбооны хэрэгслэл дутмагаас хүндрэл гарч байна. 2009 оны 7. 9 дүгээр сард болсон байгалийн аюултай үзэгдлийн тухай мэдээллийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч, сургуулийн хүүхдийг хөдөө гэрт нь явуулахгүй, малчдыг нүүдэл хийлгэхгүй, тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөнийг хязгаарлаж ажиллаа. Энэ үеэр онцын хүндрэл гараагүй өнгөрсөн.	100.0
6	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг бууруулах тухай 2009.12.2 дугаар 76	2.Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохиогдож байгаа олон нийтийг хамарсан арга хэмжээ болон нийтийн хоол, баар, рестораны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгав.	"Шуурхай бүлэг"-ийг төлөвлөгөөний дагуу ажиллуулж, хяналт шалгалтыг байнга хийж байна.	70.0
5.Төрийн захиргааны удирдлага				

